



МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 23-өдөр

Дугаар А/424

Улаанбаатар хот

Г Салбарын хүүхэд хамгааллын бодлого
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9¹.1, 9¹.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого”-ыг 1 дүгээр, “Соёлын салбарын албан хаагчийн хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн байгууллагын удирдлага нарт даалгасугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Оюунбилэг), хэрэгжилтийг хангаж, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар (Н.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Ч.НОМИН

Соёлын сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 12:00 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

СОЁЛЫН САЛБАРЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО

Нэг. Хэрэгцээ шаардлага, нийтлэг үндэслэл

1.1. Хэрэгцээ шаардлага

Монгол Улсын Засгийн газраас нийт хүн амын 38%-ийг эзэлж байгаа 0-18 хүртэлх насны хүүхдийн хуулиар олгогдсон эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг хангах, Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүн амд үзүүлж буй нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хөгжлийн үйлчилгээгээр дамжуулан хүүхдийг хамгаалахаар ажиллаж байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр булийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиудын хүрээнд хүүхэд нийгмийн бүх орчинд, хүчирхийллийн аливаа хэлбэр /дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдал/-ээс хамгаалуулах эрхтэй бөгөөд насанд хүртлээ эцэг эх, гэр бүл болон төрийн онцгой халамж, хамгаалалтад байх шаардлагатай болохыг хуульчилсан.

Түүнчлэн Соёлын тухай, Музейн тухай, Номын сангийн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Кино урлагийг дэмжих тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9¹ дүгээр зүйл Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал, 91.4. “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг соёлын болон хүүхэд, гэр булийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ” гэж заасны дагуу хүүхдийг соёлын үйл ажиллагаанд оролцуулахад эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, боловсрол олгох зайлшгүй хэрэгцээтэй байна.

Өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч, хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх¹, “Бүх нийтийн соёлын боловсрол”² арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд соёлын үйл ажиллагаа, үйлчилгээгээр дамжуулан хүүхдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, хөгжүүлэх замаар аливаа гэмт хэрэг зөрчил, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.

¹ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 1.1.2

² Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

1.2. Нийтлэг үндэслэл

1.2.1. Соёлын салбарын бүх шатны байгууллага нь /цаашид “Соёлын байгууллага” гэх/ Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмжийг мөрдөж ажиллана.

1.2.2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-д Ажил олгогч нь ажилтны ажил, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Зорилго

2.1. Соёлын байгууллага бүр ажил, үйлчилгээндээ хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Гурав. Баримтлах зарчим

- Хүүхэд өөрөө соёл, урлагийн үйлчилгээний хүртэгч
- Хүүхэд өөрөө соёл, урлагийн үйлчилгээний бүтээгч
- Тэгш оролцоотой хүүхэд хөгжиж, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг

гэсэн үндсэн зарчмыг баримтлан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.1. Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;

3.2. Соёлын үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;

3.3. Хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;

3.4. Хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;

3.5. Хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг огт хүлээн зөвшөөрөхгүй байх;

3.6. Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдалд оруулж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй хор нөлөө, сөрөг үр дагаврыг багасгах, арилгах, эрсдэлийг тооцох арга хэмжээг заавал авч ажиллана.

Дөрөв. Хамрах хүрээ

4.1. Энэхүү баримт бичиг нь соёлын байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчид болон хамтран ажиллах байгууллага, сайн дурын ажилтан, дадлагажигч ажилтан, оюутан, соёл урлагийн үйлчилгээг авч буй зочид, судлаач, хувь хүмүүст хамаарна.

Тав. Хэрэгжүүлэх заавар

5.1. Соёлын байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх өөрийн байгууллагын удирдах албан тушаалтан, ажилтны төлөөллөөс бүрдсэн /З-9 гишүүнтэй/ “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулж ажиллах ба зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.1. хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

5.1.2. хүүхэд хамгааллын бодлогыг мөрдлөг болгож, харагдахуйц газар байршуулах, сурталчлан таниулах;

5.1.3. хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах;

5.1.4. байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлж, судалгаанд үндэслэн гэр бүл, хүүхэд рүү чиглэсэн гэр бүлийн боловсрол олгох, хүүхдийн хөгжлийг дэмжих;

5.1.5. байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнээр хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар удирдлагатай хамтран ажиллах;

5.1.6. хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд хүүхдийн тусlamжийн утас 108, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага, цагдаагийн байгууллагад холбон зуучлах, мэдээлэх арга хэмжээ авч ажиллана.

5.2. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдал, орчин нөхцөлийн шаардлага хангасан байна.

5.2.1. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээнд Соёлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу холбогдох стандарт болон бусад эрх зүйн баримт бичгийг мөрдөнө.

- Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны стандарт MNS 6476: 2014;
- Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5634:2006;
- Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742: 2019;
- Соёлын төв, соёлын ордон. Орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 6981 : 2022
- Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио телевизийн хөтөлбөрийн дүрэм”;
- Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS 6587:2016 стандарт;

5.2.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16.1.2-д заасны дагуу “хүчирхийллийг илэрхийлж сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх”;

5.2.3. хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон мэдээ мэдээллээр хангах соёлын боловсрол олгох соён гагаруудах үйлчилгээ үзүүлэх;

- 5.2.4. хүүхдэд соёлын боловсрол олгох, үйлчилгээ үзүүлэх соёлын орон зайд нэмэгдүүлэх;
- 5.2.5. хүүхдийн хөгжих, бүтээлчээр сэтгэх, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх;
- 5.2.6. хүүхдийн бүтээлийг зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах, хуулбарлах, дамжуулах зэргээр хүүхдийн оюуны бүтээл алдагдахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хамгаалах арга хэмжээ авах;
- 5.2.7. "Хүүхдэд ээлтэй байгууллага" байх;
- 5.2.8. хүүхэд хамгааллын асуудлаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа авах;
- 5.2.9. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцгой хэрэгцээг хангахад чиглэсэн байх;
- 5.2.10. хүүхдийн эрх, тэгш байдлыг хүндэтгэсэн, дэмжсэн зерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх;
- 5.2.11. салбарын хэмжээнд Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний чуулганаар дэвшүүлсэн "Хөшиг нээгдэх бүрд-хүргэх нэг үг" уриалгыг хэрэгжүүлж, соёлын үзвэр, үйлчилгээ, арга хэмжээ бурийн эхэнд хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд үүргийг сануулж хэвших;
- 5.2.12. соёл, урлагийн үзвэр, үйлчилгээний худалдаалсан тасалбарын 1-ээс доошгүй хувийг өөрийн байгууллагын хэмжээнд хүүхдийн хөгжил, хамгааллын тодорхой үр дүнд хүрэхүйц ажил, арга хэмжээнд зарцуулах, хэрэгжилтийг тайлагнах;
- 5.2.13. соёлын салбарын ажилтнууд хүүхдийн эрхийн мэдлэгтэй, мэдрэмжтэй, манлайлалтай байх хандлагыг төлөвшүүлэх.

5.3. Ажилтнуудыг эцэг эхийн үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5.3.1. салбарын хэмжээнд ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах талаар заавар зөвлөгөө өгч ажиллах,

5.3.2. сургуулийн өмнөх болон бага ангийн хүүхэдтэй, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан, өрх толгойлсон эцэг, эхийн ажиллах нөхцөлийг уян хатан болгож хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулж, мөрдүүлнэ. Тухайлбал:

- богиносгосон цагаар ажиллах
- цахимаар ажиллах
- хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх, авах боломжоор хангах
- шөнийн ээлжийн ажилд өөртэй нь зөвшилцөхгүйгээр хуваарилахгүй байх
- цалингийн нэмэлт, урамшуулал дэмжлэг үзүүлэх
- бусад дэмжлэгт хамруулах

5.3.3. байгууллагын дэргэд хүүхдийн өрөө, өдөр өнжүүлэх, цэцэрлэг байгуулах санал санаачилгыг өрнүүлж, зохион байгуулах;

5.3.4. байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх,

Зургаа. Ажилтан сонгон шалгаруулахад анхаарах асуудал

6.1. Хүүхдэд хор хохирол учруулж болзошгүй хүнийг ажилд авахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд бүхий л арга хэмжээг авна.

6.2. Ажилтныг сонгон шалгаруулах үзүүлэлтэд хүүхэдтэй зүй бусаар харилцаж байсан эсэхийг нягтлах заалтыг тусгах, эрх бүхий байгууллагаас хүүхдийн эрхийн зөрчил гаргаж байсан эсэхийг тодорхойлолтоор авч болно.

6.3. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийн хавсралт 1-д заасан загварын дагуу тодорхойлолт авна.

Долоо. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм

7.1. Соёлын байгууллагууд хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэмтэй байна.

7.2. Ёс зүйн дүрмийн гол зорилго нь хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад орших бөгөөд байгууллагын ажилтны зүгээс ажлын байр, гэр бүл, нийгмийн орчинд хүүхэд хамгааллын хувьд эрсдэлтэй, зохисгүй зан үйл гаргахгүй байхад анхаарч, хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд чиглэнэ.

7.3. Нийт ажилтнууд болон шинээр ажилд орж байгаа ажилтан, албан хаагч, дадлагажигч ажилтан, оюутан Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэмтэй танилцан гарын үсэг зурж гэрээ байгуулна.

7.4. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн ажилтанд зөвлөх, зааж сургах, сахилгын арга хэмжээ авах, үүрэгт ажлаас нь өөрчлөх, түдгэлзүүлэх, чөлөөлөх эсвэл хуулийн хүрээнд шийдвэрлүүлэхээр ажлын гэрээнд /хөдөлмөрийн гэрээнд/ тусгана.

Найм. Хяналт, үнэлгээ

8.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбарын хэмжээнд хүүхдийн эрхийг хангах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг Засгийн газрын өмнө хариуцна.

8.2. Соёлын байгууллага хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хийсэн ажил, түүний чанар, үр нөлөө, зарцуулж байгаа төсөв хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож ажиллана.

8.3. Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн хийсэн ажлын тайланг жил бүр хамт олны хуралд танилцуулж санал, хүсэлт авч ажиллах ба энэхүү тайлангийн үр дүнгээс хамаарч дараа жилийн үйл ажиллагаанд зориулах төсөв хөрөнгийг батлуулна.

8.4. Хүүхэд хамгааллын чиглэлээр хийсэн жилийн үйл ажиллагааны тайлангаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт жил бүрийн 10 дугаар сарын 25-ны дотор хүргүүлж байна.

8.5. Соёлын салбарын хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд соёлын хяналтын болон хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт тавина.

Ес. Хүрэх үр дүн

9.1. Салбарын хэмжээнд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөн хэрэгжүүлснээр хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийтийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлнэ.

9.2. Соёл, урлагаар дамжуулан хүүхэд, өсвөр үе, залуусыг нийгэмшүүлэн төлөвшүүлж, эх хэл, бичиг соёл, түүх, өв уламжлалаа хүндэтгэн дээдэлдэг бүтээлч иргэнийг төлөвшүүлнэ.

9.3. Гэр бүл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлийн тоо буурч, нийгмийг соён гэгээрүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.